

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ЭРТ ИЛРҮҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ, ОНОШЛОГООНЫ ТАЙЛАН

2023 оны 05 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношлогоог зохион байгуулах журам”-ын дагуу Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь байгууллагын нийт 272 ажилтан, албан хаагчдыг эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулах үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 13-наас 04 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд зохион байгуулсан.

Нийт 272 ажилтан, албан хаагчдаас:

- 30 ажилтан, албан хаагч урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 2022 онд хамрагдсан байна.
- 2023 оны 04 сарын 13-ны өдөр 93 ажилтан, албан хаагчдаас цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ, шээсний шинжилгээг тус тус авсан.
- 2023 оны 04 сарын 15-ны өдөр 93 ажилтан, албан хаагчдаас 75 нь бусад буюу насны ангилалаар заагдсан шинжилгээнүүдэд хамрагдсан.
- 2023 оны 04 сарын 22-ны өдөр 57 ажилтан, албан хаагчид бүх заагдсан шинжилгээнд хамрагдсан
- 2023 оны 04 сарын 29-ний өдөр 20 ажилтан, албан хаагчид хамрагдсан ба нийт 170 албан хаагчид шинжилгээнд хамрагдсан.

Ходоод, улаан хоолойн дуранд:

- 2023 оны 04 сарын 15-ны өдөр 25 ажилтан, албан хаагч,
- 2023 оны 04 сарын 17-ноос 21-ны өдрийн хооронд 19 ажилтан, албан хаагч,
- 2023 оны 04 сарын 22-ны өдөр 25 ажилтан, албан хаагч,
- 2023 оны 04 сарын 24-ний өдрөөс 28-ны өдрийн хооронд 9 ажилтан, албан хаагч,
- 2023 оны 04 сарын 29-ний өдөр 17 ажилтан, албан хаагчид тус тус хамрагдсан.

Ходоод, улаан хоолойн дуранд 150 ажилтан, албан хаагч албан ёсоор хамрагдах боломжтойгоос 95 ажилтан, албан хаагчид хамрагдсан ба үлдсэн 76 ажилтан, албан хаагчид өөрийн хүсэлтээр мөн эрүүл мэндийн даатгалаа төлөөгүй учраас хамрагдаагүй болно.

Үр дүн:

- Нийт 272 ажилтан, албан хаагчдын 70% нь хамрагдсан болно.
- Эрт илрүүлэгт хамрагдсан ажилтан, албан хаагчдад холбогдох эмч нар зөвөлгөө мэдээллийг өгч, холбогдох эмчилгээг бичиж өгсөн.

Эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдсан нийт ажилтан, албан хаагчдад зонхилон тохиолдсон онош:

DS: Острый гломерулонефрит
DS: Острый гломерулонефрит
DS: Хронический гломерулонефрит
DS: Аритмия
DS: Сердечная недостаточность
DS: Артериальная гипертензия
DS: Хронический гастрит
DS: Хронический гастродуоденит
DS: Таргалалтын 1 болон 2 дугаар зэрэг

Эхо-ны үзлэгээр: цэс өтгөрсөн, нойр булчирхайн эхо ойлт ихэссэн, элэгний эхо ойлт ихэссэн, бөөрний эхо ойлт ихэссэн зарим тохиолдоод баймбайн эхо ойлт ихэссэн, хэмжээ ихэссэн, зангилаа үүссэн байсан.

Биохимийн шинжилгээ, шээсний шинжилгээнд: Бөөр, нойр булчирхай, элэгний үйл ажиллагаа доголдсон, холестерины ихсэлт зонхилон тохиолдосон байна.

Үзлэг шинжилгээний хариун дээр тулгуурласан дүгнэлтээр ажлын чиглэл, нөхцлөөс шалтгаалсан өвчлөлт их байгаа бөгөөд нийтдээ буруу хооллолт, хөдөлгөөнгүй удаан суух, нэг байрлалдаа удаан ажлаа хийх, энгийн аргаар биеийн чилээ гаргах аргуудыг мэдэхгүй, мэддэг ч хэрэгжүүлдэггүй, ямар нэг зовиур илэрвэл удааж архаг болтол нь тоохгүй явдаг, амьдралын буруу хэв маягтай, сэтгэлзүйн асуудлаа зөвөөр илэрхийлж ойлгож, ойлголцож чаддаггүйгээс үүдсэн ходоодны үрэвсэл ихтэй байгааг харуулж байна.

Эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдаж байгаа
ажилтан, албан хаагчид





Хавсралт: Тушаалд заагдсан насны ангилалаар хийгдсэн шинжилгээний жагсаалт:

18-29 насныхан

№	Шинжилгээний нэр	Тайлбар
1.	Эмчийн үзлэг	Эрт илрүүлгийн асуумж, үзлэг, эрсдлийн үнэлгээ, дүгнэлт, эмчилгээ, зөвөлгөө Жилд 1 удаа
2.	Цусны ерөнхий шинжилгээ	Жилд 1 удаа
3.	Биохимийн шинжилгээ	АЛАТ, АСАТ, шууд билирубин, амилаза, креатинин, мочевин, холестерин, триглицерид Жилд 1 удаа
4.	Шээсний ерөнхий шинжилгээ	Жилд 1 удаа
5.	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
6.	ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	
7.	Гепатит С вирусийн эсрэг бие илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
8.	Зүрхний цахилгаан бичлэг	Жилд 1 удаа
9.	Цээжний рентген зураг	Жилд 1 удаа
10.	Хэвлийн эхо	Элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, 2 бөөр

	Жилд 1 удаа
--	-------------

30-34 наснаас дээш

№	Шинжилгээний нэр	Тайлбар
1.	Эмчийн үзлэг	Эрт илрүүлгийн асуумж, үзлэг, эрсдлийн үнэлгээ, дүгнэлт, эмчилгээ, зөвөлгөө Жилд 1 удаа
2.	Цусны ерөнхий шинжилгээ	Жилд 1 удаа
3.	Биохимийн шинжилгээ	АЛАТ, АСАТ, шууд билирубин, амилаза, креатинин, мочевин, холестерин, триглицерид Жилд 1 удаа
4.	Шээсний ерөнхий шинжилгээ	Жилд 1 удаа
5.	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
6.	ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
7.	Гепатит В, С вирусийн эсрэг бие илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
8.	Зүрхний цахилгаан бичлэг	Жилд 1 удаа
9.	Цээжний рентген зураг	Жилд 1 удаа
10.	Эсийн шинжилгээ	ПАП тест (30 наснаас хойш 3 жил тутамд 1 удаа өгнө 30 нас, 33 нас, 36 нас, 39 нас г.м)
11.	Хэвлийн хэт авиа шинжилгээ	Элэг, нойр булчирхай, дэлүү, 2 бөөр, түрүү булчирхай

35-44 наснаас, 45 наснаас дээш

№	Шинжилгээний нэр	Тайлбар
1.	Эмчийн үзлэг	Эрт илрүүлгийн асуумж, үзлэг, эрсдлийн үнэлгээ, дүгнэлт, эмчилгээ, зөвөлгөө Жилд 1 удаа
2.	Цусны ерөнхий шинжилгээ	Жилд 1 удаа
3.	Биохимийн шинжилгээ	АЛАТ, АСАТ, шууд билирубин, амилаза, креатинин, мочевин, холестерин, триглицерид Жилд 1 удаа
4.	Шээсний ерөнхий шинжилгээ	Жилд 1 удаа
5.	Өлөн үеийн глюкоз	Жилд 1 удаа

6.	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
7.	ХДХВ илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
8.	Гепатит В, С вирусийн эсрэг бие илрүүлэх хурдавчилсан шинжилгээ	Жилд 1 удаа
9.	Зүрхний цахилгаан бичлэг	Жилд 1 удаа
10.	Цээжний рентген зураг	Жилд 1 удаа
11.	Эсийн шинжилгээ	ПАП тест (30 наснаас хойш 3 жил тутамд 1 удаа өгнө 30 нас, 33 нас, 36 нас, 39 нас г.м)
12.	Хэвлийн хэт авиа шинжилгээ	Элэг, нойр булчирхай, дэлүү, 2 бөөр, түрүү булчирхай Жилд 1 удаа
13.	Улаан хоолой, ходоодны дуран	35 наснаас дээш Жилд 1 удаа
14.	Бамбайн хэт авиа	40 наснаас дээш 2 жилд 1 удаа
15.	Хөхний хэт авиа	40 наснаас дээш жилд 1 удаа
16.	Зүрх судасны өвчний эрсдлийн үнэлгээ	40 дээш насанд Жилд 1 удаа

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД

АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Л.АМАРЖАРГАЛ

ХҮНИЙ ИХ ЭМЧ

Д.САНЧИРМАА